



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорнод аймгийн Чойбалсан сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ДОА-2023/187/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Чойбалсан хот
2023 он

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,

Тэргүүлэх аудитор: Б.Болортуул

Утас: 7058-4203, Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn

Аудитын менежер: И.Сэмжидмаа

Утас: 7058-4207, Цахим хаяг: semjidmaai@audit.gov.mn

Ахлах аудитор: Д.Нармандах

Утас: 7058-4207, Цахим хаяг: narmandakhd@audit.gov.mn

Аудитор М.Нурболат

Утас: 9902-7275, Цахим хаяг: lightanddelightaudit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	2
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	4
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	10
4. АУДИТЫН ТАЙЛАН	13
4.1 Ерөнхий зүйл	13
4.2 Материаллаг байдал	13
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	13
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	13
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	13
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	14
4.5.1 Завсрын аудитын талаар.....	14
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	14
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	14
5.1 Төлбөрийн акт	14
5.2 Албан шаардлага	15

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

7 дугаар баг, Хэрлэн сум, Дорнод аймаг, 21000
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2023.02.24 № 267

танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Чойбалсан сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Чойбалсан сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй болно.

Аудитын гол асуудал

Санхүүгийн тайлангийн аудитад материаллаг буруу үнэлсэн нөлөө бүхий эрсдэлтэй удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал үйл явдал гараагүй болно.

Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хангалттай зохистой гэж үзлээ.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

011020372

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ

Дорнод аймгийн Чойбалсан сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	214,159,704.65	212,107,342.00
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	26,745,694.00	69,106,526.61
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	26,745,694.00	69,106,526.61
3121	Төгрөг	26,745,694.00	69,106,526.61
31211	Төрийн сангийн харилцах	-	69,106,526.61
31217	Төрийн сангийн харилцах-Орон нутаг	26,745,694.00	
33	АВЛАГА	80,353,151.39	4,098,751.39
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	3,004.70	3,004.70
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	76,254,400.00	-
335	Бусад авлага	4,095,746.69	4,095,746.69
3351	Байгууллагаас авах авлага	3,486,277.69	3,486,277.69
3352	Хувь хүмүүсээс авах авлага	609,469.00	609,469.00
35	БАРАА МАТЕРИАЛ	107,060,859.26	138,902,064.00
351	Түүхий эд материал	35,402,940.48	86,118,116.02
35130	Эм боох материал	35,402,940.48	86,118,116.02
354	Хангамжийн материал	71,657,918.78	52,783,947.98
35410	Бичиг хэргийн материал	1,471,770.00	1,509,610.00
35420	Аж ахуйн материал	69,368,948.78	50,652,137.98
35440	Түлш, шатах тослох материал	817,200.00	59,400.00
35460	Хүнсний материал	-	562,800.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	574,669,526.21	714,525,112.53
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	574,669,526.21	714,525,112.53
392	Биет хөрөнгө	547,697,526.21	687,553,112.53
39201	Барилга, байгууламж, орон сууц	458,900,721.61	574,700,721.61
39202	Хуримтлагдсан элэгдэл	(44,806,167.89)	(62,336,279.51)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	43,930,769.20	43,930,769.20
39204	Хуримтлагдсан элэгдэл	(15,432,158.11)	(22,048,824.79)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	77,315,858.57	121,378,813.57
39206	Хуримтлагдсан элэгдэл	(32,761,511.47)	(38,079,346.76)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	39,532,552.00	53,613,995.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(13,698,261.96)	(16,290,338.43)
39214	Бусад үндсэн хөрөнгө	56,512,996.00	59,350,536.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(21,797,271.74)	(26,666,933.36)
393	Биет бус хөрөнгө	26,972,000.00	26,972,000.00
39301	Програм хангамж	662,540.00	-
39302	Хуримтлагдсан элэгдэл	(662,540.00)	-
39303	Бусад биет бус хөрөнгө	26,972,000.00	26,972,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	788,829,230.86	926,632,454.53
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	788,829,230.86	926,632,454.53
51	Засгийн газрын хувь оролцоо	788,829,230.86	926,632,454.53
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	124,683,931.36	124,683,931.36
51101	Өмч: - төрийн	124,683,931.36	124,683,931.36
512	Хуримтлагдсан үр дүн	335,342,880.27	473,146,103.94
51210	Өмнөх үеийн үр дүн	191,565,354.86	335,342,880.27
51220	Тайлант үеийн үр дүн	143,777,525.41	137,803,223.67
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	328,802,419.23	328,802,419.23
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	788,829,230.86	926,632,454.53

Дорнод аймгийн Чойбалсан сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	806,741,064.56	729,762,996.87
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	68,353,284.56	242,049,166.87
1200	Нийтлэг татварын бус орлого	68,353,284.56	242,049,166.87
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	68,353,284.56	242,049,166.87
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	45,515,694.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	68,353,284.56	
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө		159,134,696.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Материал		37,398,776.87
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	738,387,780.00	487,713,830.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	344,884,600.00	-
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	344,884,600.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	355,045,880.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	355,045,880.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	11,077,600.00	17,479,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	11,077,600.00	17,479,800.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	27,379,700.00	470,234,030.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	27,379,700.00	470,234,030.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	658,490,530.00	591,959,773.20
21	УРСГАЛ ЗАРДАЛ	658,490,530.00	591,959,773.20
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	634,613,409.00	563,905,913.20
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	315,281,090.30	300,774,826.39
210101	Үндсэн цалин	214,393,144.30	197,223,932.18
210102	Нэмэгдэл	75,623,845.00	61,005,042.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,763,000.00	4,204,999.78
210104	Урамшуулал	21,501,101.00	38,340,852.43
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	40,044,267.00	38,125,454.00
210201	Тэтгэврийн даатгал	28,030,590.00	26,819,947.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,131,824.00	3,079,160.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,505,398.00	2,387,983.00
210204	Ажилгүйдлийн даатгал	567,538.00	530,760.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,808,917.00	5,307,604.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	10,222,879.00	11,140,034.00
210301	Гэрэл, цахилгаан	4,495,297.00	3,550,176.00
210302	Түлш, халаалт	5,727,582.00	7,589,858.00
2104	Хангамж, бараа материалын зардал	25,248,466.60	63,943,613.92
210401	Бичиг хэрэг	3,848,605.60	5,966,420.00
210402	Тээвэр, шатахуун	14,667,800.00	17,322,797.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,611,200.00	1,461,600.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	584,980.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,535,881.00	25,927,853.00
210408	Бараа материал акталсны зардал	-	13,264,943.92
2105	Нормативт зардал	167,337,564.26	86,382,433.21
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	153,000,575.26	67,935,657.21
210502	Хоол, хүнс	8,904,889.00	15,739,576.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	5,432,100.00	2,707,200.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	13,103,161.00	5,257,050.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	7,651,747.00	400,000.00
210604	Урсгал засвар	5,451,414.00	4,857,050.00
2107	Томилолт, зочны зардал	1,535,000.00	5,682,000.00

**Дорнод аймгийн Чойбалсан сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

210702	Дотоод албан томилолт	1,535,000.00	5,682,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	539,446.00	5,572,952.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	3,400,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	270,000.00	270,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	107,750.00	119,250.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	60,000.00	59,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	33,000.00	33,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	1,187,500.00
210807	Газрын төлбөр	68,696.00	53,702.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	-	450,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	61,301,534.84	47,027,549.68
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	21,863,600.00	2,046,200.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	39,437,934.84	44,981,349.68
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	23,877,121.00	28,053,860.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	23,800,000.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	23,800,000.00	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	28,053,860.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	1,308,166.00
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	-	26,745,694.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	77,121.00	-
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	77,121.00	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	148,250,534.56	137,803,223.67
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	7,153,602.55	-
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	7,153,602.55	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(7,153,602.55)	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	141,096,932.01	137,803,223.67

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	662,133,380.00	609,483,924.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	17,794,100.00	121,770,094.00
120	Нийтлэг татварын бус орлого	17,794,100.00	121,770,094.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	17,794,100.00	121,770,094.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	17,794,100.00	95,024,400.00
1200047	Шилжиж ирсэн мөнгөн хөрөнгө		26,745,694.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	644,339,280.00	487,713,830.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	344,884,600.00	-
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	344,884,600.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	278,791,480.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	278,791,480.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	11,077,600.00	17,479,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	11,077,600.00	17,479,800.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	9,585,600.00	470,234,030.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	9,585,600.00	470,234,030.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	614,039,886.00	567,123,091.39
21	УРСГАЛ ЗАРДАЛ	614,039,886.00	567,123,091.39
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	590,162,765.00	539,069,231.39

**Дорнод аймгийн Чойбалсан сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	315,284,095.00	300,774,826.39
210101	Үндсэн цалин	214,396,149.00	197,223,932.18
210102	Нэмэгдэл	75,623,845.00	61,005,042.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,763,000.00	4,204,999.78
210104	Урамшуулал	21,501,101.00	38,340,852.43
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	40,044,267.00	38,125,454.00
210201	Тэтгэврийн даатгал	28,030,590.00	26,819,947.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,131,824.00	3,079,160.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,505,398.00	2,387,983.00
210204	Ажилгүйдлийн даатгал	567,538.00	530,760.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,808,917.00	5,307,604.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	10,222,879.00	12,432,534.00
210301	Гэрэл, цахилгаан	5,322,879.00	3,550,176.00
210302	Түлш, халаалт	4,900,000.00	8,882,358.00
2104	Хангамж, бараа материалын зардал	25,058,223.00	28,769,740.00
210401	Бичиг хэрэг	3,244,700.00	4,932,660.00
210402	Тээвэр, шатахуун	15,485,000.00	14,916,727.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,920,490.00	1,461,600.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	768,200.00	1,970,270.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,639,833.00	5,488,483.00
2105	Нормативт зардал	154,106,089.00	97,231,757.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	143,930,300.00	80,642,794.00
210502	Хоол, хүнс	8,280,189.00	12,552,763.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,895,600.00	4,036,200.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	21,578,966.00	41,834,865.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	4,540,000.00	14,269,900.00
210602	Тавилга	-	15,693,275.00
210604	Урсгал засвар	17,038,966.00	11,871,690.00
2107	Томилолт, зочны зардал	1,535,000.00	5,682,000.00
210702	Дотоод албан томилолт	1,535,000.00	5,682,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	539,446.00	5,583,952.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	3,400,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	270,000.00	270,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	107,750.00	119,250.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	60,000.00	59,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	33,000.00	33,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	1,198,500.00
210807	Газрын төлбөр	68,696.00	53,702.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	-	450,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	21,793,800.00	8,634,103.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	21,793,800.00	8,634,103.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	23,877,121.00	28,053,860.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	23,800,000.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	23,800,000.00	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	77,121.00	28,053,860.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	77,121.00	1,308,166.00
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг		26,745,694.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	48,093,494.00	42,360,832.61
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	21,347,800.00	-
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	21,347,800.00	-
2200	Дотоод эх үүсвэрээр	21,347,800.00	-

**Дорнод аймгийн Чойбалсан сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

225104	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн /ТӨҮГ/	21,347,800.00	-
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(21,347,800.00)	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	26,745,694.00	42,360,832.61
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	26,745,694.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	26,745,694.00	69,106,526.61
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	26,745,694.00	69,106,526.61

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/Төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	124,683,931.36	328,802,419.23	191,565,354.86	645,051,705.45
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	2,680,593.40	2,680,593.40
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	124,683,931.36	328,802,419.23	194,245,948.26	647,732,298.85
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	141,096,932.01	141,096,932.01
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	124,683,931.36	328,802,419.23	335,342,880.27	788,829,230.86
D01	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	124,683,931.36	328,802,419.23	335,342,880.27	788,829,230.86
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	124,683,931.36	328,802,419.23	335,342,880.27	788,829,230.86
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	137,803,223.67	137,803,223.67
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	124,683,931.36	328,802,419.23	473,146,103.94	926,632,454.53

Дорнод аймгийн Чойбалсан сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/Төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	632,292,500.00	540,377,397.39
21	УРСГАЛ ЗАРДАЛ	632,292,500.00	540,377,397.39
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	632,292,500.00	539,069,231.39
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	360,038,000.00	300,774,826.39
210101	Үндсэн цалин	220,977,200.00	197,223,932.18
210102	Нэмэгдэл	70,323,300.00	61,005,042.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,584,000.00	4,204,999.78
210104	Урамшуулал	63,153,500.00	38,340,852.43
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	46,106,600.00	38,125,454.00
210201	Тэтгэврийн даатгал	31,263,100.00	26,819,947.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,760,900.00	3,079,160.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,028,700.00	2,387,983.00
210204	Ажилгүйдлийн даатгал	732,100.00	530,760.00
210205	Эрүүл мэндийн даатгал	7,321,800.00	5,307,604.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	13,740,700.00	12,432,534.00
210301	Гэрэл, цахилгаан	6,094,200.00	3,550,176.00
210302	Түлш, халаалт	7,646,500.00	8,882,358.00
2104	Хангамж, бараа материалын зардал	37,317,800.00	28,769,740.00
210401	Бичиг хэрэг	6,438,500.00	4,932,660.00
210402	Тээвэр, шатахуун	19,156,500.00	14,916,727.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,770,000.00	1,461,600.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,452,800.00	1,970,270.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,500,000.00	5,488,483.00
2105	Нормативт зардал	107,779,100.00	97,231,757.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	84,423,800.00	80,642,794.00
210502	Хоол, хүнс	16,688,500.00	12,552,763.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	6,666,800.00	4,036,200.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	44,806,500.00	41,834,865.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	15,946,700.00	14,269,900.00
210602	Тавилга	16,245,700.00	15,693,275.00
210604	Урсгал засвар	12,614,100.00	11,871,690.00
2107	Томиллолт, зочны зардал	6,878,800.00	5,682,000.00
210702	Дотоод албан томиллолт	6,878,800.00	5,682,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,858,900.00	5,583,952.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,400,000.00	3,400,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	920,000.00	270,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	300,000.00	119,250.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	80,000.00	59,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	60,000.00	33,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,258,900.00	1,198,500.00
210807	Газрын төлбөр	190,000.00	53,702.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	650,000.00	450,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	8,766,100.00	8,634,103.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,766,100.00	8,634,103.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	1,308,166.00
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	1,308,166.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	-	1,308,166.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	632,292,500.00	609,483,924.00

Дорнод аймгийн Чойбалсан сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	17,479,800.00	17,479,800.00
122005	Орон нутгийн төсвөөс	17,479,800.00	17,479,800.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	123,770,100.00	121,770,094.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	123,770,100.00	121,770,094.00
122	ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ	491,042,600.00	470,234,030.00
122001	Хандив тусламж /дотоод/	491,042,600.00	470,234,030.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	69,106,526.61

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Дорнод аймгийн Чойбалсан сумын Эрүүл мэндийн төв нь эмнэлгийн анхан шатны тусламж үйлчилгээг ард иргэдэд жигд хүртээмжтэй хүргэх, иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, хүн амын амьдралын хэв маягийг өөрчлөх, зөв дадал зуршилд сургахад чиглэгдэнэ.

Алсын хараа: Хүн амд ээлтэй ЭМТ-ийн тусламж үйлчилгээг үзүүлснээр сумын хэмжээнд тэргүүлэгч байгууллага болно.

Эрхэм зорилго: Эрүүл мэндийн төвийн тусламж үйлчилгээг иргэн бүрт чанартай, аюулгүй хүртээмжтэй хүргэж, эрүүл иргэнийг бий болгох замаар дундаж наслалтыг уртасгахад оршино.

Э – Эмнэлгийн тусламж үйлчилгээг

М – Мэргэшсэн, манлайлагч хам олон

Т – Тасралтгүй чанартай, хүртээмжтэй хүргэх

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль Төрийн албаны тухай, Хөдөлмөрийн тухай хууль, Эрүүл мэндийн тухай хууль, Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хууль, Эрүүл мэндийн даатгалын тухай хууль, Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хууль хүрээнд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг ард иргэдэд хүргэн үйлчилж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дорнод аймгийн Чойбалсан сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Дорнод аймгийн Чойбалсан сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Дорнод аймгийн Чойбалсан сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 137.8 сая төгрөгөөр буюу 17.5 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	26,745.7	69,106.5	42,360.8
Авлага	80,353.2	4,098.8	(76,254.4)
Бараа материал	107,060.9	138,902.1	31,841.2
Үндсэн хөрөнгө	574,669.5	714,525.1	139,855.6
Нийт хөрөнгө	788,829.2	926,632.5	137,803.2
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	788,829.2	926,632.5	137,803.2
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	788,829.2	926,632.5	137,803.2

Мөнгөн хөрөнгө: 2022 онд гүйцэтгэлээр санхүүжилт авдаг болсон. Хүний нөөцийн дутмаг байдлаас шалтгаалан цалингийн зардал хэмнэгдсэн. Мөн хэмнэлтийн тухай хууль шинэчлэгдэн гарсантай холбоотойгоор зарим зардлыг гаргаагүй.

Авлага: 2021 оны жилийн эцэст Эрүүл мэндийн даатгалын сангаас 76.2 сая төгрөгийн авлага үүссэн. 2022 онд эрүүл мэндийн даатгалаас авах авлага барагдсантай холбоотой болно.

Бараа материал данс 138.9 сая төгрөг болж 31.8 сая төгрөгөөр өссөн нь эм боох материал 50.7 сая төгрөгөөр нэмэгдсэн нь нөлөөлсөн бол хангамжийн материал 18.8 сая төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна.

Үндсэн хөрөнгө: Үндсэн хөрөнгө нийт 184.8 сая төгрөгөөр нэмэгдсэн бөгөөд үүний 115.8 сая төгрөг нь аймгийн орон нутгийн хөгжлийн сангаас эмнэлгийн байранд хийгдсэн их засварын зардал болно. Мөн тайлант хугацаанд 44.9 сая төгрөгийн элэгдэл тооцсон байна.

Засгийн газрын хувь оролцоо данс 926.6 сая төгрөг болж 137.8 сая төгрөгөөр өссөн нь тайланд хөрөнгө нэмэгдсэнтэй холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Дорнод аймгийн Чойбалсан сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 574.0 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас санхүүжилтийг 194.0 сая, зардлыг 194.0 сая төгрөгөөр бууруулж, 380.0 сая төгрөгөөр баталсан байна. Энэ нь 2022 оны төсвийн төслийг зардалтай уялдуулан боловсруулаагүйгээс шалтгаалсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 209.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 3 хөтөлбөрийн 7 арга хэмжээг санхүүжүүлэхээр 591.0 сая төгрөгийг улсын төсвөөс санхүүжихээр байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 515.7 сая төгрөгийн, орон нутгийн төсвөөс 17.4 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 522.0 сая төгрөг буюу 88.0 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг нэг иргэнд ногдох нормативаар тооцсон зардлыг 24 сая, үндсэн мэргэжлийн тусламж үйлчилгээний зардлыг 23сая, Нэмэлт - Дээд шатны төсвөөс хуваарилсан зардлыг 22 сая төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Дорнод аймгийн Чойбалсан сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Лайт энд Дилайт Аудит ХХК-ийн гүйцэтгэх захирал М.Нурболат, аудитор Ц.Төмөрсүх, хяналтыг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Д.Нармандах, аудитын менежер И.Сэмжидмаа, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Болортуул нар тус тус хэрэгжүүлсэн.

Дорнод аймгийн Чойбалсан сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 02 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны үр дүнгийн тайлангийн нийт зардал 655.8 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 13.3 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор санхүүгийн сахилга батыг мөрдөж, ил тод байдлыг хангах, үр ашгийг нэмэгдүүлэх, үрэлгэн байдлыг хязгаарлах бодлогыг баримтлан ажилласан байна.

Тухайн байгууллагын батлагдсан орон тоон дээр дэд дарга, орлогчийн албан тушаалын ажилтан байхгүй байгаа бөгөөд авто тээврийн хэрэгсэл нь эмнэлгийн тусламж үйлчилгээ буюу төрийн хэмнэлтийн хуулийн 6 дугаар зүйлд заасан авто тээврийн хэрэгсэл ашиглах хэрэгцээ, шаардлагатай байгууллага байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Дорнод аймгийн Чойбалсан сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудит хийгдээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар 1 албан шаардлага хүргүүлсэн 21.4 сая төгрөгийн албан шаардлага биелэгдээгүй. Харин 2022 онд худалдан авалтад цахим төлбөрийн баримт бүрэн авч давтан гаргахгүй ажилласан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	1	21.496.0-	1	-	-
Нийт дүн	1	21.496.0	1	-	-

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, худалдах авах гэрээ, тайланг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуультай нийцэж байх эсэхийг үзэх.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 16.0 сая төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад залруулж, алдааг дахин давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө. Үүнд: 2021 оны зэрэгцүүлсэн тоон мэдээлэл 2021 оны аудитын тайлангийн дүнгээс зөрүүтэй илэрхийлэгдсэн 2.6 сая төгрөг, эрүүл мэндийн даатгалаас орсон санхүүжилтийн орлогыг туслах үйл ажиллагааны орлого дансанд бүртгэсэн 12.6 сая төгрөг, эмнэлгийн байранд хийсэн засварын өртгийг капиталжуулахдаа дутуу бүртгэсэн 0.8 сая төгрөгийг тус тус залруулан бүртгэл, тайланд тусгуулсан.

Аудитаар нийт 4.4 сая төгрөгийн зөрчил² илэрснээс 0.4 сая төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 4.0 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлсэн.

5.1 Төлбөрийн акт

1. Чойбалсан сумын Эрүүл мэндийн төвийн даргын 2022.03.01-ний Б/13 тоот тушаалаар 4 ажилтанд тус бүр нэг сая төгрөгийн урамшуулал олгосон бөгөөд үүнээс хувь хүний

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Дорнод аймгийн Чойбалсан сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

орлогын албан татвар суутгаагүй олгосон нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “21.1.Энэ хуулийн 14, 18 дугаар зүйлд зааснаар тодорхойлсон орлогын дүнд 10 хувиар тооцож, албан татвар ногдуулна.”, 14 дүгээр зүйлийн 14,1-д “Энэ хуулийн 7.1-д заасан цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогод албан татвар ногдуулах орлогыг тодорхойлохдоо уг орлогоос эрүүл мэндийн болон нийгмийн даатгалд төлсөн шимтгэлийг хасна.” 7 дугаар зүйлийн 7.1-д “Албан татвар төлөгчийн цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогод дараах орлогыг хамруулна:”, 7.1.1-д “ажил олгогчтой байгуулсан хөдөлмөрийн гэрээнд заасны дагуу авч байгаа үндсэн цалин, нэмэгдэл хөлс, нэмэгдэл, шагнал, урамшуулал, амралтын олговор, тэтгэвэр, тэтгэмж, тэдгээртэй адилтгах бусад орлого;” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

5.2 Албан шаардлага

1. Чойбалсан сумын Эрүүл мэндийн төв нь насжилт өндөр, он дамжсан 4.0 сая төгрөгийн авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна
Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Дорнод аймгийн Чойбалсан сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
2022 оны эхний үлдэгдэл аудитлагдсан дүнгээс зөрүүтэй илэрхийлэгдсэн.	1	2,680.6			1	2,680.6	1	2,680.6			-	-
Эрүүл мэндийн даатгалаас орсон санхүүжилтийн орлогыг туслах үйл ажиллагааны орлого дансанд бүртгэсэн.	1	12,600.0			1	12,600.0	1	12,600.0				
Эмнэлгийн байранд 115,800,000 төгрөгийн өртөгтэй засварын өртгийг капиталжуулахдаа 800,000 төгрөгөөр дутуу бүртгэсэн.	1	800.0			1	800.0	1	800.0				
Дүн	3	16,080.6	-	-	3	16,080.6	3	16,080.6	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Энэ нь насжилт өндөр, он дамжсан авлага байгаа бөгөөд тооцоо нийлж баталгаажуулаагүй.	1	4,098.8			1	4,098.8						
ЭМТ-ийн даргын 2022.03.01-ний Б/13 тоот тушаалаар 4 ажилтанд тус бүр нэг сая төгрөгийн буюу нийт 4 сая төгрөгийн урамшуулал олгосон бөгөөд үүнээс татвар суутгаагүй байна.	1	400.0	1	400.0								
Дүн	2	4,498.8	1	400.0	1	4,098.8	-	-	-	-	-	-